БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС БЭЭЖИН ХОТЫН ДӨРӨВДҮГЭЭР ДУНД ШАТНЫ АРДЫН ШҮҮХ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТУХАЙ ТОГТООЛ

（2024）京 04 民特 411 号

Өргөдөл гаргагч: Хятадын Экспорт-Импортын банк. Хаяг: Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бээжин хот, Шичэн дүүрэг, Фусинмэньнэй өргөн чөлөө, 30 тоот.

Хууль ёсны төлөөлөгч: У Фулинь, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга.

Шүүхэд төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч: Лю Жуо, Бээжингийн “Жиньлу Аньшэн” хуулийн фирмийн өмгөөлөгч.

Шүүхэд төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч: Гун Юэ, Бээжингийн “Жиньлу Аньшэн” хуулийн фирмийн Шэньжэнь дэх салбарын өмгөөлөгч.

Хариуцагч: Монгол Улсын “Болдтөмөр Ерөө гол” хязгаарлагдмал хариуцлагатай компани (Boldtumur Eruu Gol LLC). Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Сэлбэ гудамж, 00 дугаар байр.

Эрх бүхий төлөөлөгч: Пүрэвдоржийн Чулуунхүү (Chuluunkhuu Purevdorj), гүйцэтгэх захирал.

Шүүхэд төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч: Ян Юаньчин, Бээжин хотын “Хуамао Гуйгу” хуулийн фирмийн Ханьдань дахь салбарын өмгөөлөгч.

Шүүхэд төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч: Чэн Зыэнь, Бээжин хотын “Хуамао Гуйгу” хуулийн фирмийн өмгөөлөгч.

Өргөдөл гаргагч Хятадын Экспорт-Импортын банк, хариуцагч Монгол Улсын “Болдтөмөр Ерөө гол” хязгаарлагдмал хариуцлагатай компани (Boldtumur Eruu Gol LLC, цаашид “Болдтөмөр Ерөө Гол компани” гэх)-д холбогдох арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай хэргийг тус шүүх 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр үүсгэн хянан шалгав.

Хянан шалгах ажиллагаа дууссан болно.

Хятадын Экспорт-Импортын банк дараах тайлбарыг гаргав: Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комиссоос 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гаргасан (2023) CIETAC 2273 арбитрын шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү. Үйл баримт, үндэслэл: Хятадын Экспорт-Импортын банк 2011 онд Болдтөмөр Ерөө Гол компанитай “Зээлийн гэрээ” байгуулсан. Тус компани болон түүнийг бодитоор хянадаг Ли Шаоминг Монгол Улсад байрлах Лалэгаотэ төмрийн уурхайг худалдан авахад зориулан банк 200 сая ам.долларын зээл олгосон. Болдтөмөр Ерөө Гол компани өөрөө болон түүнтэй хамаарал бүхий компаниуд уг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах

баталгаа гаргасан. Болдтөмөр Ерөө Гол компани өөрийн өмчлөлийн 12 зүтгүүр, 1 800 вагоныг Хятадын Экспорт-Импортын банкинд эд хөрөнгийн барьцаа болгон барьцаалж, өөрийн эзэмшлийн MV-008888 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл, түүнээс үүсэх олборлох бүх эрх болон холбогдох эрх, ашиг сонирхлыг эрхийн барьцаа болгон барьцаалсан. Талууд “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”, “Эрхийн барьцааны гэрээ” байгуулж, Монгол Улсад хуульд заасан журмын дагуу эрхийн барьцааны бүртгэл хийлгэсэн. Болдтөмөр Ерөө Гол компани 2014 оны эцсээс гэрээний үүргээ зөрчиж, 200 сая ам.доллароос давсан зээлийн үндсэн төлбөр, хүүг төлөх хугацааг ихээхэн хэтрүүлсэн тул Хятадын Экспорт-Импортын банк 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Болдтөмөр Ерөө Гол компанийн барьцааны үүргийн хариуцлагыг хэрэгжүүлэхээр арбитрт нэхэмжлэл гаргасан. Гэвч хэргийг хянан хэлэлцэж, шийдвэрлэх явцад дараах асуудал гарсан.

Нэг. Арбитрын ажиллагаа зохисгүй, хэт удаан үргэлжилж, арбитрын дүрмийг ноцтой зөрчсөн бөгөөд ажиллагааны ноцтой доголдолтой байсан.

(1) Арбитрын комисс хэрэг үүсгэхэд хэт удаан хугацаа зарцуулсан.

Маргаан шийдвэрлэх заалтад “арбитрын ажиллагааг хятад, англи хэлээр явуулна” гэж тохиролцсон тул Хятадын Экспорт-Импортын банк 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр нэхэмжлэл гаргасныхаа дараа Арбитрын комиссын шаардлагын дагуу нэхэмжлэл болон бүх нотлох баримтыг англи хэлээр орчуулж, 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр дээрх англи орчуулгыг бүрэн хүргүүлсэн. Гэвч Арбитрын комисс 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдөр л энэ хэргийн арбитрын мэдэгдлийг гаргаж, Болдтөмөр Ерөө Гол компанид хүргүүлэх ажиллагааг эхлүүлсэн.

(2) Арбитрын комисс арбитрын бүрэлдэхүүн байгуулахад хэт удаан хугацаа зарцуулсан бөгөөд бүрэлдэхүүн байгуулсны дараах хуралдаануудын хоорондох хугацаа хэт урт байсан.

Арбитрын комиссын 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн мэдэгдлийн дагуу талууд мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор арбитрчаа сонгох ёстой байсан боловч Болдтөмөр Ерөө Гол компани тогтоосон хугацаанд арбитрчаа сонгоогүй. Энэ хугацаанд Хятадын Экспорт-Импортын банк бүрэлдэхүүн байгуулах ажлыг түргэтгэхээр Арбитрын комисстой удаа дараа утсаар болон бичгээр харилцсан. Гэвч Арбитрын комисс бүрэлдэхүүн байгуулахад хэр хугацаа шаардагдахыг урьдчилан хэлэх боломжгүй гэж мэдэгдсэн. Эцэст нь бүрэлдэхүүнийг 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр л байгуулсан. Үүний дараа хэргийг хянан хэлэлцэх урт хугацаа үргэлжилж, 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр, 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр тус тус хоёр удаа хуралдсан. Ийнхүү 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн анхны хуралдаанаас хойших хоёр дахь хуралдааныг 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр товлосон нь хоёр хуралдааны хооронд үндэслэлгүй урт хугацаа тогтоосон явдал юм. Арбитрын комисс ийм хугацаа тогтоосон талаар ямар нэг тайлбар өгөөгүй тул банк хуралдаан товлох ажиллагаанд ноцтой доголдол гарсан гэж үзэж байна.

(3) Шийдвэр гаргах хугацаа хэт удаан үргэлжилсэн нь “Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комиссын арбитрын дүрэм” (цаашид “Арбитрын дүрэм” гэх)-ийн 48 дугаар зүйлийн шийдвэр гаргах хугацааны тухай журмыг зөрчсөн.

Арбитрын бүрэлдэхүүн 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр байгуулагдсанаас 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр шийдвэр гаргах хүртэл бүтэн 40 сар өнгөрсөн нь Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлийн (1)-д “Арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш 6 сарын дотор шийдвэр гаргана” гэж заасан хугацааг ноцтой хэтрүүлсэн. Шийдвэр гаргах хугацааг удаа дараа сунгах тухай мэдэгдэлд Арбитрын шүүхийн дарга зөвшөөрсөн гэж тодорхой дурдсан боловч Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлийн (2)-т хугацааг сунгахад бодитой, хүндэтгэн үзэх шалтгаан байх бөгөөд шаардлагатай зорилгын хүрээгээр хязгаарлагдах ёстойг тодорхой заасан. Талуудын өмнө хүндэтгэн үзэх шалтгааныг тайлбарлаагүй атлаа ийм урт хугацааны турш шийдвэр гаргах хугацааг удаа дараа сунгасан нь Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлийн (1), (2)-т заасан шийдвэр гаргах хугацааны тухай журмыг илт зөрчсөн.

Түүнчлэн хэргийг хянан хэлэлцэх явцад банк шийдвэр гаргах ажиллагаа удааширч, удаа дараа хойшилсон тодорхой шалтгааныг тайлбарлахыг Арбитрын комиссоос хүссэн. Хугацааг цааш сунгавал төрийн өмч асар их эрсдэлд орохыг мөн мэдэгдэж, Арбитрын дүрмийг чанд мөрдөн банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд шийдвэрийг аль болох хурдан гаргахыг хүссэн. Гэвч Арбитрын комисс хугацааг удаа дараа сунгасан тодорхой шалтгааныг банкинд огт тайлбарлаагүй бөгөөд шийдвэрийг 2023 оны 10 дугаар сард л гаргасан.

Хоёр. Арбитрын ажиллагааны доголдол нь Болдтөмөр Ерөө Гол компанид өр төлбөрөөс зайлсхийх, өрийн үүргээс хууль бусаар мултрах янз бүрийн арга хэмжээ авах хангалттай хугацаа олгож, Хятадын Экспорт-Импортын банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ноцтой хохироон, төрийн санхүүгийн хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан.

Арбитрын комисс ажиллагааны үе шат бүрд ноцтой, үндэслэлгүй саатал гаргасан зэрэг доголдлын улмаас Болдтөмөр Ерөө Гол компани банкны эд хөрөнгийн болон эрхийн барьцааны эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах хууль бус төрөл бүрийн арга хэмжээг санаатайгаар авах хангалттай хугацаатай болж, Хятадын төрийн өмчийг завших хууль бус зорилгодоо хүрэх боломж бүрдсэн. Банк арбитрт нэхэмжлэл гаргасны дараа Болдтөмөр Ерөө Гол компани Монгол Улсад захиргааны хэрэг үүсгүүлж, уг ажиллагааны хүрээнд шүүхээр банкны холбогдох эрхийн барьцааны бүртгэлийг хүчингүй болгуулахыг оролдсон. Банк уг хэрэгт хүндрэлтэй нөхцөлд эрхээ хамгаалан оролцож, шүүхийн гурван шатны ажиллагааг дамжсаны эцэст Болдтөмөр Ерөө Гол компани захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар зорилгодоо хүрч чадаагүй. Үүний дараа тус компани нэн даруй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхээр ажилласан.

Уг эрүүгийн хэрэгт Болдтөмөр Ерөө Гол компани хуурамч нотлох баримт гарган өгч, бодит байдалтай ноцтой зөрсөн мэдүүлэг өгсөн. Монгол Улсын шүүх хангалттай

нотлох баримт цуглуулаагүй, шүүхийн ажиллагааны журмын алдаа гаргасан бөгөөд Хятадын Экспорт-Импортын банкинд хуульд заасан журмаар мэдэгдээгүй. Иймд нөхцөлд Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүх “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”, “Эрхийн барьцааны гэрээ”-г шууд хүчин төгөлдөр бус гэж үзэн, банкны эрхийн барьцааны бүртгэлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн нь банкны зээлдүүлэгчийн болон үүргийн гүйцэтгэлийн баталгаатай холбоотой эрх, ашиг сонирхлыг ноцтой хохироож, төрийн санхүүгийн хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан.

Гурав. Арбитрын шийдвэр холбогдох хуульд заасан журмыг зөрчиж, БНХАУ-ын нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан тул хүчингүй болгох ёстой.

Арбитрын шийдвэрт дурдсанаар, банкны арбитрын нэхэмжлэлийг эцэст нь хэрэгсэхгүй болгосон шалтгаан нь Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүх “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”, “Эрхийн барьцааны гэрээ”-г хүчин төгөлдөр бус гэж үзэн, маргаан бүхий эрхийн барьцааны бүртгэлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэнтэй холбоотой. Гэвч нэг талаас, БНХАУ, Монгол Улсын хооронд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай хоёр талт гэрээ байхгүй. Монгол Улсын уг эрүүгийн шийдвэрийг Хятадад хүлээн зөвшөөрөөгүй тул БНХАУ-ын хэргийн оролцогч талд эрх зүйн хүчин төгөлдөр үйлчлэлгүй. Нөгөө талаас, уг шийдвэрийн хууль ёсны болон үндэслэлтэй байдалд ноцтой доголдол байгаа учир арбитрын бүрэлдэхүүн түүнийг нотлох баримтаар хүлээн авах ёсгүй. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хэлэлцэх явцад хууль зөрчсөн олон нөхцөл гарсан, шийдвэрийн үндэслэлийн логик зөрчилтэй байсан бөгөөд чухал оролцогч болох Хятадын Экспорт-Импортын банкинд хуульд заасан журмаар мэдэгдээгүй нь түүний эрх, ашиг сонирхлыг ноцтой хохироосон. Үүний зэрэгцээ арбитрын бүрэлдэхүүн шийдвэртээ “Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг анхааралтай уншиж судалсны дараа ч уг шийдвэрийн эрх зүйн үндэслэл, тайлбар нь арбитрын бүрэлдэхүүнд огт үнэмшил төрүүлээгүй” гэж тодорхой дурдсан.

Гэтэл арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг үнэмшилтэй гэж хүлээн зөвшөөрөөгүй, мөн түүний хууль ёсны болон үндэслэлтэй байдалд ноцтой доголдол байгааг харгалзан үзсэн атлаа уг шийдвэрийг энэ хэрэгт чухал нөлөөтэй нотлох баримт, эрх зүйн баримт бичиг гэж үзэн хүлээн авч, түүнд үндэслэн банкны арбитрын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Нэг талаас, энэ нь БНХАУ-д хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг БНХАУ-ын хэргийн оролцогч талд бодитоор эрх зүйн үр дагавартай болгож, холбогдох хуульд заасан ажиллагааны журмыг зөрчсөн. Нөгөө талаас, ийм арбитрын шийдвэр нь мөн чанартаа Монгол Улс шүүх эрх мэдлийн бүрэн эрхээ урвуулан ашиглаж, Монголын талын өр төлөгчийг залилан мэхлэх, тэр ч байтугай хууль зөрчих, гэмт хэрэг үйлдэх аргаар өр төлбөрөөс зайлсхийхийг өөгшүүлсэн үйлдлийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Энэ нь банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчин, төрийн санхүүгийн хөрөнгөд ноцтой хохирол учруулаад зогсохгүй, нийтийн ашиг сонирхлын түвшинд БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын гадаадад санхүүгийн үйл ажиллагаа явуулах дэг журмыг ноцтой

алдагдуулж, санхүүгийн тогтвортой байдал, аюулгүй байдалд халдан, тодорхой этгээдээр хязгаарлагдахгүй нийт хөрөнгө оруулагчдын олон улсын санхүүгийн үйл ажиллагаанд оролцох аюулгүй байдал, итгэлийг эрсдэлд оруулсан. Иймд нийгмийн нийтийн чухал ашиг сонирхолд халдаж, хуулийн эрх тэгш, шударга ёсны үндсэн зарчим, нийтийн дэг журам, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуунд харшилсан. Мөн шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шүүхийн шийдвэрийн тогтоон барих нөлөөг сулруулж, БНХАУ-ын шүүх эрх мэдлийн бүрэн эрхт байдалд хохирол учруулсан.

Болдтөмөр Ерөө Гол компани дараах тайлбарыг гаргав:

Нэг. Болдтөмөр Ерөө Гол компани арбитрын дүрмийг зөрчиж, ажиллагааг сунжруулаагүй.

1. Хятадын Экспорт-Импортын банк арбитрын ажиллагааг үндэслэлгүй удаашруулсан. Нэгдүгээрт, банк 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр нэхэмжлэл гаргасан боловч холбогдох баримтын орчуулгыг 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр л хүргүүлж, Болдтөмөр Ерөө Гол компанид баримт бичиг хүргүүлэх хаягийг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр л баталгаажуулсан нь хэргийг хүлээн авснаас хойших ажиллагааг ноцтой удаашруулсан. Хоёрдугаарт, анхны хуралдаан 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр болсон боловч банк үндэслэлгүй удаасны эцэст 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх хүсэлт дахин гаргаснаар ажиллагаа улам сунжирсан. Эцэст нь, банк өөрийн нэхэмжлэлийн үйл баримтын үндэслэлийг санаачилгаараа тайлбарлаагүй бөгөөд шийдвэр гарахын өмнөхөн буюу 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр л шаардсаны дагуу эрхийн болон эд хөрөнгийн барьцааны зүйлийн тухайн үеийн байдлын талаар бичгээр тайлбар өгсөн. Үүнээс арбитрын ажиллагааг Хятадын Экспорт-Импортын банк өөрөө удаашруулсан нь харагдана.

2. Болдтөмөр Ерөө Гол компани Монгол Улсад захиргааны нэхэмжлэл гаргасан нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуульд нийцсэн аргаар хамгаалсан үйлдэл бөгөөд арбитрын ажиллагаа, үр дүнд нөлөөлөөгүй.

Арбитрын хэрэгт хамаарах “Эрхийн барьцааны гэрээ”-ний дагуу барьцаа нь Сэлэнгэ аймгийн Ерөө суманд байрлах Баянголын төмрийн уурхайн төслийг санхүүжүүлэх зорилготой байсан. Гэвч бодит байдалд уг төсөлд ямар ч зээлийн хөрөнгө очоогүй. Ийм нөхцөлд банк арбитрт нэхэмжлэл гаргасныг мэдсэний дараа Болдтөмөр Ерөө Гол компани өөрийн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд банкны талд хийсэн эрхийн барьцааны бүртгэлийг хүчингүй болгуулахаар Монгол Улсад захиргааны нэхэмжлэл гаргасан нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуульд нийцсэн аргаар хамгаалсан хэрэг юм. Ажиллагааг үндэслэлгүй удаашруулсан нөхцөл байхгүй.

Хоёр. Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг өөрийн шийдвэрийн үйл баримтын үндэслэл болгоогүй тул арбитрын хэрэг уг эрүүгийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх асуудалтай холбоогүй.

Арбитрын шийдвэрээс үзэхэд, бүрэлдэхүүн “Эрхийн барьцааны гэрээ”-ний заалт, маргаан бүхий хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд банкны талд хийсэн эрхийн барьцааны бүртгэл хүчингүй болсон үйл баримт, мөн эд хөрөнгийн барьцааны зүйлд банкны эрх бүртгэгдээгүй байсан үйл баримтад үндэслэн шийдвэр гаргасан. Монгол Улсын эрүүгийн шийдвэрт шүүхээс тогтоосон үйл баримтыг арбитрын хэргийг хянан хэлэлцэх үндэслэл болгоогүй. Иймд уг хэрэг Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх асуудалтай холбоогүй. 1. Ажиллагааны хувьд, Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд банкинд хууль ёсоор мэдэгдэл хүргүүлсэн. Эрүүгийн шийдвэрийн хууль ёсны байдлыг дээд шатны шүүх баталгаажуулсан бөгөөд шийдвэр хүчин төгөлдөр, эцсийн болсон. Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын залилан мэхлэх гэмт хэрэг мөрдөн шалгах нэгж нь эрх бүхий төлөөлөгчид мэдэгдэж, цахим шуудан илгээх замаар банкинд эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдэгдэн, төлөөлөгч томилохыг шаардсан. 2. Үнэн хэрэгтээ Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг банкны санаачилга, оролцоогоор эхлүүлсэн бөгөөд банк уг эрүүгийн хэргийн талаар мэдэж байсан. 3. Эрүүгийн шийдвэр нь хууль ёсны, хүчин төгөлдөр, заавал биелүүлэх шинжтэй бөгөөд нэгэнт гүйцэтгэгдсэн.

Гурав. Болдтөмөр Ерөө Гол компани арбитрын шийдвэрийн дагуу төлсөн арбитрын хураамжийг банк хүлээн авсан тул банк уг шийдвэрийг дагаж мөрдөх ёстой.

Дөрөв. Хятадын Экспорт-Импортын банк зээлд хяналт тавих үүргээ зөрчин зээлийг зохисгүй олгосны улмаас маргаан бүхий зээлийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тул үүнээс үүдсэн бүх хохирлыг өөрөө хариуцах ёстой. Энэ хэрэгт банк зээлийн хөрөнгийн зарцуулалтын чиглэлд хяналт тавих үүргээ биелүүлээгүй, зээл олгохдоо ноцтой хайхрамжгүй хандсан. Үүний улмаас зээлийг эрхийн барьцааны гэрээ болон хуульд заасан зориулалтаар огт ашиглаагүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт зарцуулаагүй, Болдтөмөр Ерөө Гол компанид ч олгоогүй. Банкны хяналт сул, зээл олгох ажиллагаанд ноцтой цоорхой байсны улмаас зээлийн хөрөнгийг хэрэгт оролцоогүй этгээд болох Ли Шаоминг бодитоор бүхэлд нь хяналтдаа авч, энэ хэргийн “Эрхийн барьцааны гэрээ”-нд тохиролцсон Монгол Улсын төмрийн уурхайд хөрөнгө оруулах зориулалтаар ашиглаагүй. Банк өөрийн ноцтой хайхрамжгүй үйлдлийн эрх зүйн хариуцлага болон түүнээс үүдсэн бүх хохирлыг хүлээх ёстой.

Тав. Арбитрын бүрэлдэхүүн зөвхөн нэхэмжлэгч, хариуцагчийн хоорондын эрх, үүргийн талаар шийдвэр гаргасан бөгөөд уг шийдвэр БНХАУ-ын нийгмийн нийтийн ашиг сонирхолтой холбоогүй, түүнд харшлаагүй.

Банк болон Болдтөмөр Ерөө Гол компани нь эрх зүйн байдлын хувьд тэгш худалдаа, аж ахуйн субъектүүд юм. (2023) CIETAC 2273 арбитрын шийдвэр нь зөвхөн тэдгээрийн хоорондын гэрээний эрх, үүргийн харилцааг шийдвэрлэсэн бөгөөд нийгмийн бусад гишүүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг шууд болон шууд бусаар хөндсөн нөхцөл байхгүй. Иймд уг шийдвэр нийтийн ашиг сонирхолтой холбоогүй бөгөөд түүнд харшлаагүй. Тиймээс “нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан”

гэх үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан банкны тайлбар үндэслэлгүй.

Хянан шалгалтаар тогтоосон нь: 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Хятадын Экспорт-Импортын банк Болдтөмөр Ерөө Гол компанитай байгуулсан “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”, “Эрхийн барьцааны гэрээ”-ний арбитрын заалтад үндэслэн Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комисст (цаашид “Арбитрын комисс” гэх) нэхэмжлэл гаргасан. Арбитрын комисс нэхэмжлэлийг хүлээн авч, X20191266 дугаар хэрэг үүсгэсэн. 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Арбитрын комисс (2023) CIETAC 2273 шийдвэр гаргаж, Хятадын Экспорт-Импортын банкны арбитрын нэхэмжлэлийн бүх шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Энэ хэргийн арбитрын хураамж 480 000 юань бөгөөд банк, Болдтөмөр Ерөө Гол компани тус бүр хагасыг буюу 240 000 юанийг хариуцахаар шийдвэрлэсэн. Банк 480 000 юанийг урьдчилан төлж, уг төлбөрийг хэргийн арбитрын хураамжид тооцсон тул Болдтөмөр Ерөө Гол компани шийдвэр гарсан өдрөөс хойш хорин (20) хоногийн дотор банкинд 240 000 юань төлөх ёстой.

Тус шүүхийн дүгнэлт: Энэ хэрэг нь гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар тал хүсэлт гаргасан хэрэг тул “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Арбитрын тухай хууль”-ийн 70 дугаар зүйлд заасны дагуу “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” (2023 оны нэмэлт, өөрчлөлттэй)-ийн 291 дүгээр зүйлд заасан асуудлыг хянан шалгана. Тус хуулийн 291 дүгээр зүйлд: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гадаадын оролцоотой маргаан шийдвэрлэх арбитрын байгууллагаас гаргасан шийдвэрт дор дурдсан нөхцөлийн аль нэг байгааг хариуцагч нотлох баримтаар нотолсон бөгөөд ардын шүүх шүүх бүрэлдэхүүн байгуулан хянан шалгаж, баталгаажуулсан бол уг шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах тухай тогтоол гаргана: (1) талууд гэрээндээ арбитрын заалт тусгаагүй, эсхүл маргаан гарсны дараа бичгээр арбитрын хэлэлцээр байгуулаагүй; (2) хариуцагч арбитрч томилох, эсхүл арбитрын ажиллагаа явуулах тухай мэдэгдэл аваагүй, эсхүл өөрөөс нь үл шалтгаалах бусад шалтгаанаар тайлбар гаргах боломжгүй байсан; (3) арбитрын бүрэлдэхүүний бүтэц, эсхүл арбитрын ажиллагаа нь арбитрын дүрэмд нийцээгүй; (4) шийдвэрлэсэн асуудал нь арбитрын хэлэлцээрийн хүрээнд хамаарахгүй, эсхүл арбитрын байгууллага тухайн маргааныг шийдвэрлэх эрх хэмжээгүй байсан. Ардын шүүх уг шийдвэрийг гүйцэтгэх нь нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилна гэж үзвэл гүйцэтгэхээс татгалзах тухай тогтоол гаргана гэж заасан. Дээрх заалт нь ардын шүүх гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хуульд заасан үндэслэл мөн. Талын гаргасан хүсэлтийн үндэслэл эдгээрт нийцэхгүй бол гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болгож болохгүй.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох ёстой гэж Хятадын Экспорт-Импортын банкны гаргасан үндэслэлд тус шүүх дараах дүгнэлт хийв:

Арбитрын ажиллагаа зохисгүй явагдсан гэх банкны тайлбарын тухайд: банк арбитрын ажиллагаа хэт удаан үргэлжилсэн, мөн арбитрын шийдвэр нь БНХАУ-д хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг БНХАУ-ын хэргийн оролцогч талд эрх зүйн үр дагавартай болгосон гэж үзжээ. Тус шүүхийн үзэж байгаагаар, “Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комиссын арбитрын дүрэм”-ийн 48 дугаар зүйлд шийдвэр гаргах хугацааны талаар (1) арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш 6 сарын дотор шийдвэр гаргана; (2) арбитрын бүрэлдэхүүний хүсэлтээр, Арбитрын комиссын Арбитрын шүүхийн дарга бодитой, хүндэтгэн үзэх шалтгаан болон шаардлага байна гэж үзвэл уг хугацааг сунгаж болно; (3) ажиллагаа түдгэлзсэн хугацааг дээрх (1)-д заасан шийдвэр гаргах хугацаанд оруулж тооцохгүй гэж заасан. Хэргийг хянан хэлэлцэх, ажиллагааг үргэлжлүүлэх бодит хэрэгцээ байсан тул арбитрын бүрэлдэхүүний хүсэлтээр Арбитрын шүүхийн дарга маргаан бүхий шийдвэрийг гаргах хугацааг эцсийн байдлаар 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүртэл сунгахыг зөвшөөрч, шийдвэрлэсэн. Уг арбитрын шийдвэрийг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гаргасан учир хянан хэлэлцэх хугацааг хэтрүүлээгүй бөгөөд арбитрын дүрэмд нийцээгүй нөхцөл байхгүй. Үүний зэрэгцээ арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг өөрийн шийдвэрийн үйл баримтын үндэслэл болгоогүй. Арбитрын шийдвэрт дурдсанаар, Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүх “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”, “Эрхийн барьцааны гэрээ”-г эцэслэн хүчин төгөлдөр бус гэж үзэж, маргаан бүхий эрхийн барьцааны бүртгэл буюу MV-008888 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн барьцааны бүртгэлийг хүчингүй болгосон. Арбитрын бүрэлдэхүүн уг бүртгэлийг DGMC хүчингүй болгосон бодит байдлыг өөрчлөх эрхгүй тул банк энэ арбитрын хэрэгт хэрэгжүүлэхийг хүссэн эрхийн барьцаа бодит байдалд оршин байхаа больсон, банк уг барьцааны эрх эзэмшигчийн хувьд эрхээ бодитоор хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж үзжээ. Банкнаас маргаан бүхий эд хөрөнгийн барьцааны талаар гаргаж өгсөн шинжээчийн дүгнэлтэд үндэслэвэл, банкны анх үүссэн эд хөрөнгийн барьцааны эрхийг мөн “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”-г эрүүгийн хэргийн шүүх хүчин төгөлдөр бус гэж үзсэн тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. Түүнчлэн банкны эд хөрөнгийн барьцааны эрх, ашиг сонирхол зөвхөн бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно гэж үзсэн ч “Эд хөрөнгийн барьцааны гэрээ”-ний талууд уг барьцааг бодитоор бүртгүүлсэн гэдгийг нотлох ямар ч баримт байхгүй. Ийм нөхцөлд арбитрын бүрэлдэхүүн хүчин төгөлдөр эд хөрөнгийн барьцаа байхгүй гэж дүгнэсэн. Иймээс арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн шийдвэрт шүүхээс тогтоосон үйл баримтыг арбитрын хэргийг хянан хэлэлцэх үндэслэл болгоогүй бөгөөд уг хэрэг нь Монгол Улсын эрүүгийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх асуудалтай холбоогүй. Арбитрын дүрэмд нийцээгүй нөхцөл байхгүй. Банкны дээрх тайлбарыг тус шүүх хүлээн авахгүй.

Арбитрын шийдвэр БНХАУ-ын нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан гэх банкны тайлбарын тухайд: тус шүүхийн үзэж байгаагаар, нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшлах гэдэг нь нийт нийгэм ашиг хүртэгч нь болох, нийгмийг бүхэлд нь хамарсан эрх зүй, ёс суртахууны хамгийн суурь нийтлэг ашиг сонирхолд харшлахыг

хэлнэ. Энэ нь БНХАУ-ын эрх зүйн үндсэн тогтолцоо, зарчимд харшлах, нийгэм, эдийн засгийн амьдралын суурь үнэт зүйлсийн чиг баримжааг зөрчих, нийтийн болон ахуйн амьдралын дэг журмыг аюулд учруулах, нийгмийн бүх гишүүн нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг ёс суртахууны үндсэн хэм хэмжээнд харшлах байдлаар илрэх ёстой. Маргаан нь эрх тэгш иргэний эрх зүйн субъектүүдийн хоорондын иргэний маргаан бөгөөд арбитрын шийдвэрийн үйлчлэл тэдгээрийн хоорондын эрх, ашиг сонирхолд хамаарна. Уг шийдвэр нь банкны тайлбарласан шиг БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын гадаадад санхүүгийн үйл ажиллагаа явуулах дэг журмыг ноцтой алдагдуулсан, санхүүгийн тогтвортой байдал, аюулгүй байдалд халдсан, тодорхой этгээдээр хязгаарлагдахгүй нийт хөрөнгө оруулагчдын олон улсын санхүүгийн үйл ажиллагаанд оролцох аюулгүй байдал, итгэлийг эрсдэлд оруулсан нөхцөл байгааг одоо байгаа нотлох баримтаар нотлох боломжгүй. Үүний зэрэгцээ Хятадын Экспорт-Импортын банкны санхүүгийн хөрөнгө нь нийгмийн нийтийн ашиг сонирхолтой адил утгатай биш юм. Арбитрын шийдвэр нийтийн ашиг сонирхолд харшилсан гэх банкны тайлбарыг тус шүүх хүлээн авахгүй.

Дээр дурдсанаар, Хятадын Экспорт-Импортын банкны арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан үндэслэлүүд тогтоогдохгүй тул уг шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлтийг тус шүүх хүлээн авахгүй.

“Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Арбитрын тухай хууль”-ийн 70 дугаар зүйл, “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 291 дүгээр зүйлийг баримтлан ТОГТООХ нь:

Хятадын Экспорт-Импортын банкны хүсэлтийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

Хүсэлт гаргасны хураамж болох 400 юанийг Хятадын Экспорт-Импортын банк хариуцна (төлсөн).

Даргалагч шүүгч Ван Шян

Шүүгч Чэн На

Шүүгч Ли Шяорүй

тамга

Бээжин хотын Дөрөвдүгээр дүнд шатны ардын шүүх

2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Шүүгчийн туслах Ма Шяоянь

Нарийн бичгийн дарга Цао Жялу